



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 177

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 32.1.10, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зудын гамшгийг эрсдэл багатай даван туулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааны бичиг хэрэг, холбооны зардал мөн малчдад өвс, тэжээл хүргэх, зам гаргах ажлыг зохион байгуулахад шаардлагатай хоол, хүнс, шатахууны зардлуудыг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох арга хэмжээнд шаардагдах 2,300,000 (хоёр сая гурван зуун мянга) төгрөгийг аймгийн хандив, тусламж, нөөцийн бараа, материалаас гаргахыг Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Х.Сүхбаатар), 1,670,600 (нэг сая зургаан зуун далан мянга, зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4217400159

2
2 3

Аймгийн Засаг даргын 2024 оны
 02 дугаар сарын 26-ны өдрийн
 А/с/7 дугаар захирамжийн
 хавсралт

Шуурхай штабын холбоо, бичиг хэргийн зардлын төсөв

| № | Зардалын төрөл | Тоо ширхэг | Үнэ /төгрөг/ | Нийт /төгрөг/ |
|------|--|------------|--------------|----------------|
| 1 | Суурин утасны дугаар /7054-0110/ сар тутам | 3 | 13200 | 39600 |
| 2 | Суурин утасны дугаарын ярианы эрх /7054-0110/ 1 удаа | 3 | 3000 | 9000 |
| 3 | Үүрэн утасны дугаар /8043-0105/ 1 удаа | 1 | 15000 | 15000 |
| 4 | Принтерийн хор өнгөт | 4 | 10000 | 40000 |
| 5 | Принтерийн хор хар | 1 | 55000 | 55000 |
| 6 | Бичгийн цаас | 4 | 18000 | 72000 |
| Нийт | | | | 230,600 |

Өвөлжилт хүндэрсэн зорилтот малчин өрхүүдэд өвс, тэжээл хүргэх алба хаагчдын хоолны зардлын төсөв

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Тайлбар |
|-----|----------------|-------------|------------|----------------|------------------|-----------------------|
| 1 | Хоолны мөнгө | ш | 60 | 24 000 | 1 440 000 | 10 хоног 6 алба хаагч |
| Дүн | | | | | 1 440 000 | |

Өвөлжилт хүндэрсэн зорилтот малчин өрхүүдэд өвс, тэжээл хүргэх шатахууны зардлын төсөв

| № | Чиглэл | Автомашин | Төрөл | Туулах км | Шаардагдах шатахуун /л/ | Литр үнэ | Мөнгөн дүн |
|------------------|-----------|---------------------|-------|-----------|-------------------------|----------|--------------------|
| 1 | 6-р баг | Прадо 11-88 ГСа | АИ-92 | 624 | 100 | 2490 | 250,000.0 |
| 2 | | Патрол 00-31 ГСа | ДТ | 624 | 100 | 3680 | 370,000.0 |
| 3 | 5-р баг | Патрол 00-62 ГСа | ДТ | 416 | 80 | 3680 | 295,000.0 |
| 4 | | 00-33 ГСа | АИ-92 | 416 | 70 | 2490 | 180,000.0 |
| 5 | 4-р баг | 29-39 гса, Ланд 105 | АИ-92 | 524 | 90 | 2490 | 225,000.0 |
| 6 | | 08-81 ГСа Прадо | АИ-92 | 524 | 90 | 2490 | 225,000.0 |
| 7 | Баянтал | 24-78 УБЗ | АИ-92 | 500 | 90 | 2490 | 225,000.0 |
| 8 | Баянтал | 79-19 ГСа | АИ-92 | 500 | 45 | 2490 | 105,000.0 |
| 9 | Шивээговь | 00-86 гса ланд-100 | АИ-92 | 330 | 60 | 2490 | 150,000.0 |
| 10 | | ЭМГ-ын 03-09 ГСа | АИ-92 | 330 | 60 | 2490 | 150,000.0 |
| 11 | ОБГ | 01-05 ГСа | АИ-92 | 624 | 50 | 2490 | 125,000.0 |
| Нийт дүн: | | | | | 835 | | 2,300,000.0 |

